НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

*Дотоод албан хэрэгцээнд*

# ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

## нэг. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 24-нна өдрийн байдлаар буюу **43-р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 12 аймагт **1612** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.

**1206**
Эмнэлэгийн тусламж авч буцсан

**377**
Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан

**23**
(Сэжигтэй 3)
Нас барсан




| Эр | Эм |
|---|---|
| 761 (47%) | 851 (53%) |

Хүүхэд (0-17 нас)
**672**

Насанд хүрэгч (18< нас)
**940**

**Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:**

Угаарын хийн хордлогод өртсөн 1612 тохиолдлын 95% /1522/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 5% /88/ нь орон нутагт (Баян-Өлгий /12/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Дорноговь /3/, Дорнод /4/, Орхон /4/, Өвөрхангай /12/, Өмнөговь /3/, Сэлэнгэ /1/, Төв /25/, Ховд /1/, Хөвсгөл /8/), тодорхойгүй /2/ бүртгэгдсэн байна. Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **447** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.



# 43 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2026.10.18 – 2026.10.24)

2026 оны дөчин гуравдугаар долоо хоногт угаарын хийн хордлого 67 тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 1.52 хувиар, 5 жилийн дунджаас 13.9 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.




## ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **1-43-р долоо хоногт** нийт **1512** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.

| 680 | 821 | 10 | ЭМ | ЭР |
|---|---|---|---|---|
| Эмнэлэгийн тусламж авч буцсан | Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан | Нас барсан | 743 (49%) | 769 (51%) |




Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 насны иргэд хамгийн их хордлогод өртөж байна.

2026 оны **дөчин гуравдугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **55** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 48.6 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 164 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.




*Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (43-р долоо хоногт)*

| № | Шалтгаан (Сэдэл) | Санаатай | Санамсаргүй | Нийт |
|---|---|---|---|---|
| **1** | Химийн бодисын хордлого | 19 | 12 | 31 |
| **2** | Эмийн хордлого | 11 | 13 | 24 |
| **Нийт** | | **30** | **25** | **55** |

Нийт 55 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 24 (44%) нь эмийн хордлого, 31 (56%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 25 (45%) тохиолдол, санаатай хордлого 30 (55%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-o0o-